



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2009 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 273

Улаанбаатар хот

“Урт хугацааны даатгагчийн хөрөнгөөс хөрөнгө оруулалт хийх хөрөнгийн хэмжээ, түүнд тавигдах шаардлага”-ыг шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13.1.3, 14.2.4 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.“Урт хугацааны даатгагчийн хөрөнгөөс хөрөнгө оруулалт хийх, түүнд тавигдах шаардлага”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Энэ журмыг 2010 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны “Урт хугацааны даатгагчийн дүрмийн сан болон нөөц сангаас хөрөнгө оруулалт хийх хөрөнгийн хэмжээ, түүнд тавигдах шаардлага”-ыг батлах тухай 85 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Батлагдсан журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

УРТ ХУГАЦААНЫ ДААТГАГЧИЙН ХӨРӨНГӨӨС ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ, ТҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

НЭГ.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь Даатгалын тухай хуулийн 14.2.4, 25.2, 25.3 дахь заалтуудын дагуу Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэнэ)-ноос урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд (цаашид “даатгагч” гэх)-ийн хөрөнгийг эрсдэл багатай, хөрвөх чадвартайгаар байршуулахад оршино.

1.2.Даатгагчийн хөрөнгийг хөрөнгө оруулалтад байршуулах зорилго нь даатгалын зах зээлийн тогтвортой хөгжлийг хангах, даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах, нөөц сангаас даатгуулагч нарт даатгалын гэрээний дагуу олгох нөхөн төлбөрийн шаардлагыг хангахад хүрэлцэхүйц найдвартай, баталгаатай байлгахад оршино.

1.3.Даатгалын тухай хуулийн 80 дугаар зүйлд заасан урт хугацааны сангийн зохицуулалтэнэ журамд үл хамаарна.

ХОЁР.Хөрөнгө оруулалтад тавигдах шаардлага

2.1.Даатгагчийн хөрөнгөөс хөрөнгө оруулалт хийхэд дараах шаардлагууд тавигдана:

2.1.1.Даатгагч нь Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-өөр баталгаажуулсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөтэй байх бөгөөд уг төлөвлөгөөнд энэ журмын 2.3-т заасан зүйлийг тусгасан байна;

2.1.2.Даатгагч нь хөрөнгө оруулалтын төлөвлөгөө болон түүнийхээ биелэлтийг Хороонд жил бүр ирүүлж байна;

2.1.3.Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг энэ журмын 3.1.1-3.1.10-т заасан хязгаарлалтын хүрээнд боловсруулсан байна.

2.2.Хэрэв даатгагч нь гадаад улсад хөрөнгө оруулалт хийхийг хүсвэлэнэ тухай хүсэлтээ Хороонд албан бичгээр ирүүлж, зөвшөөрөл авна.

2.3. Даатгагч нь хөрөнгө оруулалтын төлөвлөгөөндөө дараах зүйлсийг тусгана:

2.3.1. Энэ журмын 3.1 -т заасан хязгаарлалт дээр үндэслэсэн тухайн компанийн хөрөнгө хуваарилах байдал;

2.3.2.Энэ журмын 3.1-т заасан хөрөнгө оруулалтын хувь хэмжээ;

2.3.3.Өөрийн компанийн даатгалын болон давхар даатгалын үйл ажиллагааны байдлыг тусгасан даатгалын компанийн эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө;

2.3.4.Төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийн зохистой харьцаа;

2.3.5.Даатгуулагчдын өмнө хүлээсэн хариуцлага болон хөрөнгө оруулалтад байршуулсан хөрөнгийн эргэн төлөгдөх хугацаа;

2.3.6.Даатгагчийн үйл ажиллагаатай холбоотой үүсч болзошгүй бусад эрсдэлийг хэрхэн удирдах талаар;

2.3.7. Даатгалын тохиолдол үүсэхэд учирсан хохирол буюу хэлэлцэн тохирсон даатгалын нөхөн төлбөрийг төлөх үүргээ бүрэн хэрэгжүүлэх зорилгоор даатгагч нь хөрөнгө оруулалтад байршуулсан хөрөнгийг шуурхай татан төвлөрүүлж, хохирлыг хэрхэн барагдуулах талаар.

2.4. Даатгагчийн гүйцэтгэх удирдлага нь хөрөнгө оруулалтыг ТУЗ-ын баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу гүйцэтгэнэ.

2.5. ТУЗ нь холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлт, эрсдэлийн удирдлага, мэдээлэл, дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл болон хөндлөнгийн аудитын үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж ажиллана.

ГУРАВ. Хөрөнгө оруулалтад байршуулах

3.1. Даатгагч нийт хөрөнгөөс дараах хувь хэмжээгээр тооцон хөрөнгө оруулалтад байршуулж болно:

3.1.1 Банкны хадгаламжид 100 хүртэл хувь. Үүнд: даатгагчийн мөнгөн хөрөнгийг Даатгалын тухай хуулийн 27.1.5 дахь заалтад зааснаас бусад банкны хадгаламжид байршуулахдаа нэг банкинд нийт мөнгөн хөрөнгийн 30 хувиас хэтрэхгүйгээр хадгалуулна;

3.1.2. Банкны харилцахад 100 хүртэл хувь. Үүнд: даатгагчийн мөнгөн хөрөнгийг Даатгалын тухай хуулийн 27.1.5 дахь заалтад зааснаас бусад банкны харилцах дансанд байршуулахдаа нэг банкинд нийт мөнгөн хөрөнгийн 30 хувиас хэтрэхгүйгээр байршуулна;

3.1.3. Засгийн газрын бонд 100 хүртэл хувь;

3.1.4. Орон нутгийн засаг захиргааны бонд 20 хүртэл хувь. Үүнд: нэг засаг захиргааны бондод 10 хувиас ихгүй байна;

3.1.5. Компанийн бонд 10 хүртэл хувь. Үүнд: нэг компанийн бонд 10 хувиас ихгүй байна;

3.1.6. Төв банкны үнэт цаас 60 хүртэл хувь;

3.1.7. Банкны хадгаламжийн сертификат 10 хүртэл хувь;

3.1.8. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас 30 хүртэл хувь;

3.1.9. Санхүүгийн болон үйл ажиллагааны лизинг 5 хүртэл хувь;

3.1.10. Хөрөнгө оруулалтын сан /Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 6.2.1-д заасан нээлттэй, эсхүл хаалттай санг ойлгоно./	20%
---	-----

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 276 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/

3.1.11. Үл хөдлөх хөрөнгө 25 хүртэл хувь. */Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 499 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан./*

3.1.12. МХБ-ийн хувьцаат компанийн хувьцаа	I ангилал	10%
	II ангилал	5%

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 276 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/

3.1.13. Тухайн даатгалын компанийн холбогдох этгээдэд үл хамаарах банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулах мөнгөн хөрөнгө	20%
---	-----

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 276 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан/

3.2. Даатгагч нь хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө оруулалт хийхээсээ өмнө Хороонд бичгээр мэдэгдэнэ.

ДӨРӨВ.Хөрөнгө оруулалтад тавих хяналт

4.1. Даатгагчийн өөрийн хөрөнгөөс хийх хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд Хороо хяналт тавина.

4.2. Даатгагч нь хөрөнгө оруулалтын тайланг Хорооноос баталсан маягтын дагуу гаргаж, Хороонд улирал тутам ирүүлнэ.

ТАВ.Хүлээлгэх хариуцлага

5.1. Хороо нь энэ журмын хэрэгжилтэд хяналт тавих бөгөөд журмыг зөрчсөн тохиолдолд Даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--ooOoo--